

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/09/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.2.25 № 01/105
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримтын иж бүрдэл хангаагүй 58,395.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа букуу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2022-2023 онд “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 3,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумдад хадлан бэлтгэх техник тоног төхөөрөмж хуваарилан олгосон байна. Үүний үр дүнд 169 иргэн, аж ахуйн нэгжийн 2083 га талбайд үйлчилгээ үзүүлснээс гадна, 35450 боодол ногоон тэжээл, 74800 боодол байгалийн хадлан бэлтгэсэн байна. Мөн эрчимжсэн мал аж ахуйг дэмжин сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх уламжлалт соёлыг түгээх ажлыг зохион байгуулснаар 110.1 сая литр сүү хүн амын хэрэгцээнд нийлүүлжээ.

Аудитын гол асуудал

Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/192 тоот дугаар сайдын тушаалаар Хүнсний хангамж, аюулгүй байдал хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө шилжүүлэх болон дэмжлэгийн нөхцөл тогтоож, хуваарийн дагуу 461,789.4 мянган төгрөгийн хүнсний ногооны үр хуваарилагдан ирснээс 80 хувийг хөнгөлөн 20 хувь буюу 92,357.8 мянган төгрөгийг төвлөрүүлэх үүрэг хүлээж ажилласан байна. Хөдөө аж ахуйн яаманд 49,026.9 мянган төгрөгийн үрийн төлбөрийг төвлөрүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 хөтөлбөр 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 96,93 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>81,997,466.51</u>	<u>279,039,725.51</u>
33	АВЛАГА	-	12,083,391.47
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,200,000.00
335	Бусад авлага	-	9,883,391.47
3351	Байгууллагаас авах авлага	-	2,877,693.30
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	7,005,698.17
35	БАРАА МАТЕРИАЛ	81,997,466.51	105,459,363.73
351	Түүхий эд материал	9,161,445.52	9,832,145.52
35110	Тусгай зориулалттай материал	9,161,445.52	9,161,445.52
35130	Эм боох материал	-	670,700.00
354	Хангамжийн материал	72,836,020.99	95,627,218.21
35410	Бичиг хэргийн материал	1,812,580.20	5,083,604.42
35420	Аж ахуйн материал	63,879,469.37	76,022,489.37
35440	Түлш, шатах тослох материал	-	7,377,153.00
35470	Бусад хангамжийн материал	7,143,971.42	7,143,971.42
36	НӨӨЦИЙН БАРАА	-	161,496,970.31
36200	Үрийн нөөц	-	161,496,970.31
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>760,226,734.14</u>	<u>782,969,080.98</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	760,226,734.14	782,969,080.98
392	Биет хөрөнгө	675,879,452.49	699,142,950.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	271,390,500.89	291,390,500.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	(48,000,717.21)	(53,681,510.33)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	309,381,816.00	402,181,816.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(129,134,213.62)	(215,472,853.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	284,873,818.53	302,808,387.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,280,538.33)	(70,680,938.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,086,512.46	47,475,021.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,122,526.15)	(28,226,672.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,384,800.00	33,384,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,700,000.08)	(10,035,600.12)
393	Биет бус хөрөнгө	84,347,281.65	83,826,130.65
39301	Программ хангамж	8,788,946.00	8,788,946.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,916,664.35)	(3,437,815.35)
39303	Бусад биет бус хөрөнгө	78,475,000.00	78,475,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>842,224,200.65</u>	<u>1,062,008,806.48</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>711,000.75</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>842,224,200.65</u>	<u>1,061,297,805.73</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	842,224,200.65	1,061,297,805.73

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	852,893,123.24	852,893,123.24
51101	Өмч: - төрийн	852,893,123.24	852,893,123.24
512	Хуримтлагдсан үр дүн	(10,703,122.59)	208,370,482.49
51210	Өмнөх үеийн үр дүн	(251,918,494.10)	(10,703,122.59)
51220	Тайлант үеийн үр дүн	241,215,371.51	219,073,605.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,200.00	34,200.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	842,224,200.65	1,062,008,806.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	953,671,156	1,424,235,729
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	489,934,307	543,222,229
120	Нийтлэг татварын бус орлого	489,934,307	543,222,229
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	489,934,307	543,222,229
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	489,934,307	543,222,229
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	463,736,849	881,013,500
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	404,797,400	787,617,000
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	404,797,400	787,617,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,939,449	93,396,500
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000	26,342,624
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,000,000	15,316,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,939,449	51,737,876
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	552,697,984	964,751,805
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,697,984	964,751,805
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	448,245,432	856,116,156
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,732,609	497,738,540
210101	Үндсэн цалин	191,944,773	287,131,794
210102	Нэмэгдэл	30,873,031	154,223,682
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,060,000	36,723,915
210104	Урамшуулал	7,854,805	19,659,150
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,759,418	62,258,752
210201	Тэтгэврийн даатгал	21,596,404	42,408,604
210202	Тэтгэмжийн даатгал	2,540,753	4,962,537
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,032,603	4,107,447
210204	Ажилгүйдлийн даатгал	508,151	1,024,183
210205	Эрүүл мэндийн даатгал	5,081,507	9,755,981
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,786,900	41,561,291

210301	Гэрэл, цахилгаан	3,339,962	3,687,065
210302	Түлш, халаалт	24,600,038	35,228,616
210303	Цэвэр, бохир ус	846,900	2,645,610
2104	Хангамж, бараа материалын зардал	30,792,170	30,750,733
210401	Бичиг хэрэг	2,302,100	5,161,783
210402	Тээвэр, шатахуун	26,230,617	22,973,627
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,353,883	1,117,004
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	905,570	1,498,320
2105	Нормативт зардал	-	74,050
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	74,050
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000	47,094,379
210604	Урсгал засвар	10,000,000	47,094,379
2107	Томилолт, зочны зардал	1,456,000	17,954,000
210702	Дотоод албан томилолт	1,456,000	17,954,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,019,729	84,063,634
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,012,929	74,260,775
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,008,000
210803	Даатгалын үйлчилгээ	1,655,500	811,300
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	136,920
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	55,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,200,000	5,280,000
210807	Газрын төлбөр	151,300	2,511,639
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,698,606	74,620,777
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,442,100	5,811,850
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,256,506	68,808,927
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,452,552	108,635,649
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,075,000	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,643,178	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	431,822	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,377,552	108,635,649
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,377,552	108,635,649
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	400,973,172	459,483,924
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	159,757,800	240,410,319
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	159,757,800	240,410,319
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(159,757,800)	(240,410,319)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	241,215,372	219,073,605

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>463,736,849</u>	<u>881,013,500</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	463,736,849	881,013,500
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	404,797,400	787,617,000
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	404,797,400	787,617,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,939,449	93,396,500
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000	26,342,624
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,000,000	15,316,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,939,449	51,737,876
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>463,736,849</u>	<u>881,013,500</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	463,736,849	881,013,500
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	359,284,297	772,377,851
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,732,609	499,938,540
210101	Үндсэн цалин	191,944,773	289,431,794
210102	Нэмэгдэл	30,873,031	154,123,682
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,060,000	36,723,915
210104	Урамшуулал	7,854,805	19,659,150
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,759,418	62,258,752
210201	Тэтгэврийн даатгал	21,596,404	42,408,604
210202	Тэтгэмжийн даатгал	2,540,753	4,962,537
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,032,603	4,107,447
210204	Ажилгүйдлийн даатгал	508,151	1,024,183
210205	Эрүүл мэндийн даатгал	5,081,507	9,755,981
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,786,900	40,975,200
210301	Гэрэл, цахилгаан	3,339,962	3,687,065
210302	Түлш, халаалт	24,600,038	34,642,525
210303	Цэвэр, бохир ус	846,900	2,645,610
2104	Хангамж, бараа материалын зардал	19,706,100	33,999,324
210401	Бичиг хэрэг	318,640	3,245,500
210402	Тээвэр, шатахуун	17,968,177	29,675,980
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,419,283	1,077,844
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,115,070	76,172,569
210601	Багаж, техник, хэрэгсэл	63,580	21,592,570
210604	Урсгал засвар	11,051,490	54,579,999
2107	Томилолт, зочны зардал	1,456,000	17,954,000
210702	Дотоод албан томилолт	1,456,000	17,954,000

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,036,000	39,279,466
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,229,200	29,476,607
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,008,000
210803	Даатгалын үйлчилгээ	1,655,500	811,300
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	136,920
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	55,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,280,000
210807	Газрын төлбөр	151,300	2,511,639
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,692,200	1,800,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,692,200	1,800,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,452,552	108,635,649
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,075,000	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,643,178	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	431,822	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,377,552	108,635,649
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,377,552	108,635,649

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	852,893,123.24	34,200.00	-251,918,494.10	601,008,829.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	852,893,123.24	34,200.00	-251,918,494.10	601,008,829.14
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	241,215,371.51	241,215,371.51
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	852,893,123.24	34,200.00	-10,703,122.59	842,224,200.65
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	852,893,123.24	34,200.00	-10,703,122.59	842,224,200.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	852,893,123.24	34,200.00	-10,703,122.59	842,224,200.65
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	219,073,605.08	219,073,605.08
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	852,893,123.24	34,200.00	208,370,482.49	1,061,297,805.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	645,942,518.90	733,673,060.00	(87,730,541.10)	113.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	595,942,518.90	733,673,060.00	(137,730,541.10)	123.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,000.00	50,000.00	-	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	354,480,600.00	478,941,049.00	(124,460,449.00)	135.1
210101	Үндсэн цалин	244,703,700.00	289,431,794.00	(44,728,094.00)	118.3
210102	Нэмэгдэл	97,598,900.00	133,126,190.00	(35,527,290.00)	136.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,178,000.00	36,723,915.00	(24,545,915.00)	301.6
210104	Урамшуулал	-	19,659,150.00	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,310,100.00	59,633,993.00	(15,323,893.00)	134.6
210201	Тэтгэврийн даатгал	30,130,900.00	40,551,115.00	(10,420,215.00)	134.6
210202	Тэтгэмжийн даатгал	3,544,800.00	4,770,719.00	(1,225,919.00)	134.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,835,800.00	3,816,576.00	(980,776.00)	134.6
210204	Ажилгүйдлийн даатгал	709,000.00	954,144.00	(245,144.00)	134.6
210205	Эрүүл мэндийн даатгал	7,089,600.00	9,541,439.00	(2,451,839.00)	134.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,018,200.00	40,975,200.00	(25,957,000.00)	272.8
210301	Гэрэл, цахилгаан	962,500.00	3,687,065.00	(2,724,565.00)	383.1
210302	Түлш, халаалт	13,225,600.00	34,642,525.00	(21,416,925.00)	261.9
210303	Цэвэр, бохир ус	830,100.00	2,645,610.00	(1,815,510.00)	318.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,307,300.00	27,162,784.00	(25,855,484.00)	2,077.8
210401	Бичиг хэрэг	102,400.00	3,245,500.00	(3,143,100.00)	3,169.4
210402	Тээвэр, шатахуун	1,082,200.00	22,839,440.00	(21,757,240.00)	2,110.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	122,700.00	1,077,844.00	(955,144.00)	878.4
2105	Норматив зардал	18,200.00	-	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,200.00	-	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	173,700.00	76,172,569.00	(75,998,869.00)	43,852.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	93,700.00	21,592,570.00	(21,498,870.00)	23,044.4
210604	Урсгал засвар	80,000.00	54,579,999.00	(54,499,999.00)	68,225.0
2107	Томилолт, зочны зардал	93,000.00	9,968,000.00	(9,875,000.00)	10,718.3
210702	Дотоод албан томилолт	93,000.00	9,968,000.00	(9,875,000.00)	10,718.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,317,600.00	39,019,466.00	12,298,134.00	76.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,000,000.00	29,216,607.00	-	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,600.00	1,008,000.00	(777,400.00)	437.1
210803	Даатгалын үйлчилгээ	811,300.00	811,300.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	142,700.00	136,920.00	5,780.00	95.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	58,900.00	55,000.00	3,900.00	93.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,280,000.00	-	-
210807	Газрын төлбөр	74,100.00	2,511,639.00	(2,437,539.00)	3,389.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,809,500.00	1,800,000.00	9,500.00	99.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,809,500.00	1,800,000.00	9,500.00	99.5

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	468,528,200.00	787,617,000.00	(319,088,800.00)	168.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	468,528,200.00	787,617,000.00	(319,088,800.00)	168.1
122005	Орон нутгийн төсвөөс	468,528,200.00	787,617,000.00	(319,088,800.00)	168.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийг ханган мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээг хөгжүүлэх, орлого бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилго тавин хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого, хөтөлбөр, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн, мал аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэр, хөнгөн хүнс, хоол үйлдвэрлэл, хоршооны үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах, хүн амыг эрүүл баталгаат, шим тэжээллэг хүнсээр хангаж төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх төрийн байгууллага юм.

Алсын хараа: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэр хоршоо дотоод худалдаа үйлчилгээний салбарыг олон улсын зах зээлд өрсөлдөхүйц хөгжлийн шинэ шатанд гаргаж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

Эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэний сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хөдөлмөрийн харилцаанд оролцогч захиргаа, ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, ажилтныг томилох, чөлөөлөх, хөдөлмөрийг оновчтой зохион байгуулах урамшуулах, мэргэжлийг дээшлүүлэх, ажил төлөвлөх, тайлагнах, үнэлэх, мэдээлэх, түүнчлэн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах, байгууллага, иргэдтэй харилцах, хөдөлмөрийн дэг ёс тогтоох, сахих харилцааг зохицуулах зорилготой байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын бүтэц орон тоог Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/18 дугаартай тушаалаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбоотойгоор 27 хүний орон тоогоор баталсан.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлгийн салбарыг оновчтой нэгдсэн бодлогоор хангагч, худалдааны чөлөөт байдлыг дэмжих чиг үүргийг хэрэгжүүлдэг, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрлэлийн яамны харьяа байгууллага юм.

Стратегийн тэргүүлэх чиглэл нь:

- Мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалан, хүнсний болон хөнгөн, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ хоршоо, худалдааны маркетингийн бодлого боловсруулах, тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх
- Малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, нөөцийг тогтоох, үнэлэх, бүртгэх, ашиглах

- Мал, амьтан, таримал ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, малын тэжээл, түүний нэмэлтийн хорио цээр, экспорт импортын бодлого
- Тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглах, эргэлтэд оруулах
- Байгалийн гэнэтийн аюул, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамгаалах урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах
- Хөнгөн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, өндөр технологийн шинэ салбар хөгжүүлэх, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндсийг тавих, мэдээллийг технологийн хөгжилд нийцүүлэн төр хувийн хэвшлийн түншлэлийг ханган, бизнесийн таатай орчныг бий болгоход сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хяналтыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх юм.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Малын генетик нөөцийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Шалгагдагч байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд ХХААХҮЯ-ны хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтын шалгалтаар дотоод хяналт шалгалтыг оновчтой зохион байгуулах, хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэх, сайдын тушаалаар хөндөлттэй нөхцөлөөр худалдан борлуулахаар үрийн хуваарилалтыг ил тод явуулаагүй, шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг алдаа дутагдал зөрчлүүд давтагдаж байгаа нь дотоод хяналтын хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 210,660.2 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	00.0	12,083.4	12,083.4
Бараа материал	81,997.5	105,459.4	23,461.9
Нөөцийн бараа	00.0	161,496.9	161,496.9
Үндсэн хөрөнгө	760,226.7	782,969.1	13,617.9
Нийт хөрөнгө	842,224.2	1,062,008.8	210,660.2
Богино хугацаат өр төлбөр		711,000.7	711,000.7
Засгийн газрын оролцоо	842,224.2	1,052,173.4	209,949.2
Хуримтлагдсан үр дүн	(10,703.1)	199,246.08	188,542.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	842,224.2	1,052,884.4	210,660.2

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт авлага, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Авлага 2 иргэнээс авах хөндөлттэй зээлийн үрийн авлага 7,005.7 мянган төгрөг, Аялгуут жаргалант ХХК-аас авах үрийн авлага 2,877.7 мянган төгрөг, цалингийн авлага 2,200.0 мянган төгрөг, нийт 12,083.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 23,461.9 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал 670.7 мянган төгрөг, аж ахуйн материал 12,156.0 мянган төгрөг, түлш шатах тослох материал 7,377.1 мянган төгрөг, бичиг хэрэгсэл 3,270.5 мянган төгрөг, үрийн нөөцийн бараа 161,496.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 13,617.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 100 жилийн ойн хандиваар Хөх баян булаг ХХК нь 8 ханатай гэр 20,000.0 мянган төгрөгөөр орлогдсон, хөрөнгө худалдаж авсан 11,440.0 мянган төгрөг, Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотой шилжүүлэн авсан тээврийн хэрэгсэл 92,800.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 7,050.2 мянган төгрөг, тавилга эд хогшил 2,708.5 мянган төгрөгөөр балансас балансад шилжин ирсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 595,942.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой зардлыг тус тус нэмэгдүүлэн 697,218.2 мянган төгрөгөөр баталсан байна. Хүнс, Хөдөө аж ахуйн газрын төсвийн төслийг нэмэгдүүлсэн нь албан хаагчдын цалин 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдсэн, мэргэжлийн хяналтын газар татан буугдсан нь төлөвлөгөөг нэмж батлах шалтгаан болсон байна. Төсвийг үндэслэлтэй батлуулдаггүй, баталгаажуулдаггүй, баталсан тодотгосон төсвийг аудитад ирүүлээгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 101,275.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 697,218.2 мянган төгрөгийг олгохоор баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 787,617.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 964,751.8 мянган төгрөг буюу 122 хувьтай зарцуулж, 108,635.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Энэ нь мэргэжлийн хяналтын газар татан буугдаж цалин, зардал, бараа материал, хөрөнгө шилжин ирсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70805 – ХАА, газар тариалан Үндсэн үйл ажиллагаа	697,218.2	680,708.7	16,509.4	97.6%
2	70417- Мэргэжлийн хяналт	21,366.3	20,007.2	1,359.1	93.6%
3	70801-Мал аж ахуйг хөгжүүлэх	35,416.5		35,416.5	
4	70803-Хүнсний үйлдвэрлэл хөгжүүлэх	33,616.0	32,957.2	658.8	98.04%
5	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	39,592.0		39,592.0	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХ-өөс 26,342.6 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 15,316.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого 51,737.9 мянган төгрөг орж

Нэмэлт санхүүжилтийн данснаас цалингийн зардалд 16,626.5 мянган төгрөг төгрөг зарцуулсан. Нийт зарцуулалт гүйцэтгэлийг, буцаан төвлөрүүлсэн гүйцэтгэлийн тайланг гаргаагүй байна.

Хүснэгт 2. Нэмэлт дансны төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70805 – ХАА, газар тариалан Нэмэлт	41,896.7	38,704.5	3,192.2	92.3%

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл зардлыг буруу илэрхийлсэн. Батлагдсан төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг хийгээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ын аудитор Б.Дашням гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 24 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 552,697.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 8,290.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой цалин, шимтгэл, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, шаардлагагүй зардлыг гаргахгүй байх зэргээр хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаагүй. Албан томилолт, цалин хөлс, тээвэр шатахууны зардлуудыг батлагдсан төсвөөс

хэтрүүлэн ажилласан байгаа нь байгалийн цаг агаарын нөхцөл цас зудын эрсдэлтэй байдлаас шалтгаалсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

4.4.1.1. Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 171 мэдээллээс хугацаанд нь 147 мэдээлэл байршуулсан, хугацаа хоцорсон 6 мэдээлэл байршуулж, 18 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагыг өссөн дүнгээр оруулаагүй байна. Шилэн дансанд байршуулан оруулах 161,307.4 мянган төгрөгийн үнэ бүхий мэдээллээс 130,108.4 мянган төгрөгийн мэдээлэл байршуулж 31,199.0 мянган төгрөгийн мэдээлэл дутуу мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудтай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Хүнсний хангамж, аюулгүй байдал хөтөлбөрийн хүрээнд Хүнс хөдөө аж ахуйн яамнаас тушаалаар хуваарилагдан олгосон ногооны үрийн 461,789.5 мянган төгрөгийн нөөцийн барааг олгохдоо бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан ажиллаагүй 161,496.9 мянган төгрөгийн үрийн үлдэгдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэн ажилладаг байх, ил тод байх, мэдээлэл авах эрхийг ханган ажиллах зөвлөмж өгөв.

4.4.2.2 Улсын бүртгэлийн гэрчилгээнд хөрөнгийн хэмжээ 390,977.2 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 852,893.1 мянган төгрөг буюу 461,915.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн заалт болон УСНББОУС-1 Санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу үйл явдал, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын оролцоог үнэн зөв бүртгэх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар санхүүгийн баримтыг аудитад ирүүлээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 42,875.1 мянган төгрөгийн зөрчил илэрч 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчил давтан гарсан байгаад албан шаардлага, төлбөрийн акт тогтоов.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	42875,1	0		0
Нийт дүн	2	42875.1	0		0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал: Үүнд.

1. Төсөв, санхүүжилтийг үндэслэлтэй хариуцлагатай баталдаг, хяналттайгаар захиран зарцуулж байгааг авч үзэх
2. Цахим баримтын хяналтыг хэрэгжүүлэн ажилладаг байх, төрийн чиг үүргийг оновчтой удирдлагаар ханган хэрэгжүүлэн ажиллах, дотоод хяналтын үр нөлөөг авч үзэх
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шинэ хөдөө төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хадлан тэжээл бэлтгэх 27 иж бүрдлийн талаарх, эзэмшил, ашиглалтын талаар тайлан, бүртгэл хяналт, хэрэгжилт, бусад төсөл, хөтөлбөрийн үр нөлөөг сайжруулан ажиллах талаар анхаарал хандуулах
4. Шалгагдагч байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгжийн үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийн биелэлт, хэрэгжилт дотоод хяналтын тайлан үзэх
5. Нөөцийн бараа материал, хөрөнгийн хяналтыг сайжруулан ажиллаж байгааг анхаарч, үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

5.1.1 Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд 9,124.3 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэж тайлагнасан байгааг залруулан бүртгэсэн.

5.1.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн дүнг 50,000,000.0 мянган төгрөг гэж зөрүүтэй бүртгэсэн, 49,950.0 мянган төгрөгөөр залруулан тайлагнасан.

Аудитаар нийт 343,604.9 мянган төгрөгийн алдаа зөрчил¹ илэрснээс, 17,811.4 мянган төгрөгийн 2 акт тогтоож, 183,710.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлж, 80,728.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүллээ.

5.2 Төлбөрийн акт

5.2.1 Шалгагдагч байгууллага нь тайлант онд дулааны төлбөр 14,541.1 мянган төгрөгийг илүү төлбөр төлж авлага үүсгээгүй захиран зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д “төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” заалт, Санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт”, “толилуулга”, “эрх үүрэг” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн”, 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэснийг үндэслэн төсөвт төвлөрүүлэх акт тогтоов.

5.2.2 Шалгагдагч байгууллага нь тайлант онд бичиг хэргийн 3,270.0 мянган төгрөгийн зардлыг баримтгүйгээр, төсөв хэтрүүлэн захиран зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-д “бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

5.3.1 Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Хүнс хөдөө аж ахуйн яамнаас хуваарилагдан ирсэн хүнсний ногооны үрийн үлдэгдэл 32,416.0 мянган төгрөг байгаа нь төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ил тод хариуцлагатай байдал алдагдсан, бүртгэлээр тавих хяналт хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна, 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, тохиолдсон байх, эрх үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн хөрөнгө бодитоор оршин байхгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3.2 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авалт хийх, анхан шатны цахим баримтын бүрдэлд 40,584.3 мянган төгрөгийн цахим баримт илүү шивэгдсэн зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3.3 Хувь хүн иргэнд гэрээгүй, баримтжуулаагүй олгосон 9,883.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, тулган баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “толилуулга” батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтыг үндэслэн зөрчлийг арилгаж авлагыг төсөвт төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.3.4 Шалгагдагч байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайланг тайлагнахдаа улсын төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв бэлтгээгүй, хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй, удаа дараа шаардуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зарлагын гүйлгээ хийхдээ гэрээгүй, анхан шатны баримтаар баримтжуулаагүй зөрчлийг давтан гаргасан.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт Цалингийн тооцооны дэлгэрэнгүй бүртгэлээр цалингийн тооцооны бүртгэлийг 580,947.2 мянган төгрөг, санхүүгийн тайлангаар 500,219.2 мянган төгрөгийн цалин олгосон 80,728.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт”, “эрх үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бүртгэлийг хөтлөхдөө үнэн зөв баримтжуулан хянаж баталгаажуулдаг байх зөвлөмж өгөв.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт Шинэ хөдөө төслөөр хөнгөлөлттэй зээлээр хүлээн авсан үндсэн хөрөнгө дугуйт трактор 56,309.1 мянган төгрөг, үр суулгах машин 33,463.6 мянган төгрөг, хадуур 24,227.3 мянган төгрөг, хаман боогч 48,181.8 мянган төгрөг нийт 162,818.8 мянган төгрөгийн хөрөнгө нь нийт 27 суманд хүнс хөдөө аж ахуйн яамнаас даргын тушаалаар хуваарилагдан ирсэн боловч хяналт хэрэгжээгүй шалгагдагч байгууллагын нэрээр бүртгэлтэй боловч тооллогоор бодитоор оршин байхгүй, дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, баримтжуулаагүй, төслийн хяналтыг хэрэгжүүлэгч нь өөрөө эзэмшиж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, эрх үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл хөтөлбөрийг хяналттай байлгах, хяналт шинжилгээг хариуцлагатай хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Өгсөн зөвлөмж: Төсөл хөтөлбөрийг хяналттай байлгах, хяналт шинжилгээг хариуцлагатай хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд 9,124.3 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн	1	9,124.3			1	9,124.3	1	9,124.3				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн дүнг 50,000,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн	1	49,950,000.0			1		1					
Дүн	2	49,959,124.3			2	49,959,124.3	2	49,959,124.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баримтжуулаагүй дулааны төлбөр	1	14,541.10	1	14,541.10								
Баримтгүй төсөв хэтрүүлэн зарцуулсан	1	3,270.30	1	3,270.30								
Цахим баримт илүү бүртгэсэн	1	40,584.30			1	40,584.30						
Авлагыг тооцоо нийлж баримтжуулаагүй баримтгүй	1	9,883.40			1	9,883.40						
Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавиагүй	1	32,416.00			1	32,416.00						
Бодитоор оршин байхгүй хөрөнгө	1	162,181.80					1	162,181.80				
Цалингийн бүртгэл зөрүүтэй тооцоолсон	1	80,728.00					1	80,728.00				
Хариуцлага тооцуулах	1				1							
Дүн	8	343,604.90	2	17,811.40	4	82,883.70	2	242,909.80				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 31,199.0 мянган төгрөг өссөн дүнгээр дутуу оруулсан, хугацаа хоцроосон 1 мэдээлэл, 146 мэдээлэл байршуулаагүй байна.	1	31,199.0	1	31,199.0		
Дүн	1	31,199.0	1	31,199.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Засгийн газрын оролцоо сан зөрүүтэй	1	661,196.2			1	661,196.2
Төслийн хөрөнгө оруулалтын хяналтыг хэрэгжүүлээгүй	1				1	
Дүн	2	661,196.2			2	661,196.2
Нийт дүн	3	692,391.6	1	31,199.0	2	661,196.2



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 63-14510516-ТӨА-2024/09/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тайлант онд дулааны төлбөр 14,541,100 /арван дөрвөн сая таван зуун дөчин нэгэн мянга нэг зуун/ төгрөгийг илүү төлбөр төлж, авлага үүсгээгүй захиран зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д "төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.3-д "үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" заалт, Санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт", "толилуулга", "эрх үүрэг" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дулааны төлбөр илүү төлсөн 14,541,100 /арван дөрвөн сая таван зуун дөчин нэгэн мянга нэг зуун/ төгрөгийг Төв аймгийн Төрийн сан дахь Тө.Хүү, торгуулийн орлогын 100140000988 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Н.Гантулга, нягтлан бодогч Б.Бямбасүрэн нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.ОЮУНГЭРЭЛ



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 64-14510516-ТӨА-2024/09/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар бичиг хэргийн 3,270,300 /гурван сая хоёр зуун далан мянга гурван зуун/ төгрөгийн зардлыг анхан шатны баримтгүйгээр захиран зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүй зарцуулсан 3,270,300 /гурван сая хоёр зуун далан мянга гурван зуун/ төгрөгийг Төв аймгийн Төрийн сан дахь Тө.Хүү, торгуулийн орлогын 100140000988 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Н.Гантулга, нягтлан бодогч Б.Бямбасүрэн нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.ОЮУНГЭРЭЛ



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 84-14510516-ТӨА-2024/09/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Хүнс хөдөө аж ахуйн яамнаас хуваарилагдан ирсэн хүнсний ногооны үрийн үлдэгдэл 32,416,000 /гучин хоёр сая дөрвөн зуун арван зургаан мянган/ төгрөг байгаа нь төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ил тод хариуцлагатай байдал алдагдсан, бүртгэлээр тавих хяналт хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна, 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөл хөтөлбөрийн хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

019040520

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Н.Гантулга, нягтлан бодогч Б.Бямбасүрэн нарт даалгав.



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.ОЮУНГЭРЭЛ



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 83-14510516-ТӨА-2024/09/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 40,584,300 /дөчин сая таван зуун наян дөрвөн мянга гурван зуун/ төгрөгөөр илүү бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “ холбогдох олон улсын стандарт , эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Н.Гантулга, нягтлан бодогч Б.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.ОЮУНГЭРЭЛ

019040530

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 81-14510516-ТӨА-2024/09/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 31,199,000 /гучин нэгэн сая нэг зуун хорин ерэн есөн мянган/ төгрөг өссөн дүнгээр зөрүүтэй мэдээлсэн, хугацаа хоцорсон 6 мэдээлэл, 18 мэдээлэл байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Н.Гантулга, нягтлан бодогч Б.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.ОЮУНГЭРЭЛ

019040008

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 80-14510516-ТӨА-2024/09/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч нь аудитаас шаардсан санхүүгийн тайлан мэдээллийг хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй, удаа дараа шаардуулсан өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зарлагын гүйлгээ хийхдээ гэрээ, анхан шатны баримтаар баримтжуулаагүй зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах.", 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ¹ гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040296

1. Хүнс, хөдөө аж ахуйн газарт нягтлан бодогчоор ажиллаж байхдаа дээрх зөрчлийг гаргасан Б.Бямбасүрэнд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт² ирүүлэхийг Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Б.Ганхуягт даалгав.



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/

²Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 82-14510516-ТӨА-2024/09/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хувь хүн иргэнд гэрээгүй олгосон 9,883,400 /есөн сая найман зуун наян гурван мянга дөрвөн зуун/ төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, тулган баталгаажуулаагүй байгаа зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар дугаар зүйлийн, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тооцоо нийлж, тулган баталгаажуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Н.Гантулга, нягтлан бодогч Б.Бямбасүрэн нарт даалгав:

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.ОЮУНГЭРЭЛ

019040521